

Монгол нялхсын өлгийн зүүвэр наадгайн бэлгэдэл дэх үндэсний үнэт зүйлсийн уламжлал, утга агуулгын судалгаа

Ганболдын Дүүриймаа 

Соёл урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, ахисан түвшний
хөтөлбөрийн алба, Улаанбаатар, Монгол Улс
 gleaf1109@gmail.com

Баянзулын Мөнхцэцэг 

Соёл урлагийн их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Энэхүү өгүүлэл нь монгол нялхсын өлгийн зүүвэр наадгайн соёлын агуулга, бэлгэдэл, түүхэн уламжлал болон өнөөгийн хэрэглээний онцлогийг шинжлэх ухааны үүднээс судалсан бүтээл юм. Монголчуудын “Хүнээр хүн хийх монгол арга ухаан”-ы илэрхийлэл болсон нялх хүүхдийн тоглоом наадгайн зүйлс нь хүүхдийн танин мэдэхүйн суурь хөгжлийг дэмжих, үндэсний үнэт зүйлсийг өвлүүлэх, хамгаалах үүрэгтэй болохыг баримтаар нотолсон. Судалгаанд түүхэн сурвалж судлал, соёлын антропологи, угсаатны зүй, сэтгэл судлалын хандлага болон бэлгэдэл зүйн шинжилгээний арга зүйг хослуулан ашигласнаар өлгийн зүүвэр наадгайн бэлгэдэлд шингэсэн үндэсний үнэт зүйлсийг илрүүлж, түүний хүмүүжлийн ач холбогдлыг тогтоов.

Түлхүүр үгс: *өв соёл, өлгийн зүүвэр наадгай, монгол уламжлал, хүүхдийн хүмүүжил, соёлын адилсал, бүтээлч үйлдвэрлэл*

A study of the traditional and symbolic significance of National values embodied in Mongolian infant cradle pendant toys

Duuriimaa Ganbold 

Research and Advanced program department, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
 gleaf1109@gmail.com

Munkhtsetseg Bayanzul 

Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

Abstract: This paper explores the cultural content, symbolism, historical continuity, and contemporary usage of Mongolian cradle pendant toys for infants. These artifacts, deeply rooted in the Mongolian philosophy of “raising a person through the wisdom of being human” serve not merely as toys but as foundational tools for cognitive development and transmission of national values. Through perspectives from cultural anthropol-

ogy, ethnology, and modern psychology, the study demonstrates how these symbolic objects support early childhood enculturation and reinforce moral, spiritual, and familial values. By employing methods from historical source analysis, cultural anthropology, ethnography, psychology, and symbolic interpretation, this study reveals the national values encoded in Mongolian cradle pendant toys and demonstrates their significance in child development and moral education.

Keywords: *intangible cultural heritage, cradle pendant toy, Mongolian tradition, child upbringing, cultural identity, creative industries*

Оршил

Хүн төрөлхтний даяаршил, шинжлэх ухаан технологийн шинэ эрин үе буюу аж үйлдвэрлэлийн IV хувьсгалын нөлөөгөөр улс орнуудын амьдралын нөхцөл байдалд эрс өөрчлөлт гарснаар залуу үеийнхний оюун санаа, амьдралын тухай үзэл бодол урьд өмнөх үеийнхээс нэлээд олон талаар өөрчлөгдсөн гэж үзэж болохоор дүр зураг харагддаг. Дэлхий нийтээр даяаршиж, нийгмийн амьдралын дүр төрх хурдацтайгаар өөрчлөгдөж, хөгжилтэй гэгдэх орнуудын соёлын нөлөөнд буурай хөгжилтэй орнууд татагдан орсоор байна. Амьдралд гарч буй сайн сайхан, хөгжил дэвшлийн төлөөх хүсэл эрмэлзэл, түүний үр дүн нь бүгд нийтээр зэрэгцэн хөгжих боломжийг бүрдүүлж байгаа ч залуу үеийнхний дунд үндэсний уламжлалаа үл хайхран бусдын соёлын нөлөөнд хэт автаж, даган дуурайх, ахмад үеэ үгүйсгэх, эд хөрөнгө, албан тушаалд шунах гэх мэт хүний ёсонд харш зүйлс байнга давтагдсаар..., сүүлийн үед хүүхдүүд хэлд орохдоо монголоор биш англиар хэлд орж байгаа нь бидний амьдралын энгийн үзэгдэл мэт болох хандлагатай болж ирлээ. Өнөөгийн энэ байдал улс үндэстэн оршин байх, эсвэл эс орших тухай асуудлыг ч хөндөж буй талаар эрдэмтэн судлаач, ахмад үеийнхэн анхааруулсаар хэдэн арван жил боллоо. Мөн Монгол Улсын Төрийн бодлогод ч тусаж Үндсэн хуулиас эхлээд бүх шатны зохих хууль дүрэм журам, баримт бичгүүдэд үндэсний өв соёлоо хадгалан хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, судлан сурталчлах, хэрэглээ болгох, дархлаажуулах гэх мэт олон заалт, зааврууд тусгагдсан байдаг ч тэр нь бодит амьдрал дээр хэрэгжих нь тун ховор учраас өнөөгийн монгол залуусын дунд гаднын соёлыг илүүд үзэж, өөрийн үндэсний соёлыг үл хайхран хүнийсэх үзэгдэл илт хавтгайрч, хүүхэд залуучуудын бодол, сэтгэлгээ хүмүүжилд гарч буй өөрчлөлтүүд нь үндэснийхээ уламжлал, ёс суртахуун, зан заншил гэх мэтчилэн үндэсний өвөрмөц онцлогтой соёлоо улам бүр мартсаар байгаа нь бодит үнэн юм. Жишээлбэл, манай залуус жил бүрийн 10 дугаар сард “сүнсний баяр” буюу “Halloween”-ий өдөр хэмээх гаднын соёлын нөлөөг хүртэж, ихээхэн ач холбогдол өгч тэмдэглэдэг болсоор бараг 20-оод жилийн нүүр үзэж байна. Эцэг эхчүүд ч хүүхдүүдээ баярлуулахын тулд энэ баярт зориулж багагүй хөрөнгө мөнгө зарцуулж байгаа нь харагддаг. Мөн манай үндэсний соёлд байдаг шинээр төрсөн хүүхдийг хамгаалах дом хэмээн уламжлан ирсэн эсгий үнэг, тээг тэргүүтэй нялх хүүхдийн зүүвэр наадгайтай утга нэгтэй, америкийн уугуул индианчуудаас гаралтай “Зүүд манагч” буюу “Dream catcher” хэмээх зүйл сүүлийн үед монгол залуусын дунд дэлгэрч, залуус түүнийг ихэд шүтэж, бэлэг дурсгалын зориулалтаар гадаадаас

худалдан авах, захиалгаар хийж худалдаж борлуулж байна. Залуусын сонирхлыг татаад байгаа энэ зүйл бидний өөрсдийн уламжлалт соёлд эртнээс байсан төдийгүй, одоо ч бид хэрэглэсээр байгаа үндэсний соёлын өв билээ. Энэ талаар ард иргэд, ахмад үеийнхэн, судлаачид санаа зовнин ярьж, хэлж, бичиж тэмдэглэж байгаа ч үр дүн нь төдийлөн хангалтгүй байгаа нь төрийн бодлого, судалгаа шинжилгээний ажил, бодит амьдралын хооронд амьд холбоо сул байгааг харуулж буй хэрэг гэж үзэж болохоор байна. Иймээс, хүүхэд залуучуудыг монгол сэтгэлгээтэй монгол хүн болгон төлөвшүүлж байж монголоо монголоор нь авч үлдэх бололцоотой бөгөөд үүнд судалгааны үндэслэлтэй хандаж, өвөг дээдсээс уламжлуулж үлдээсэн өв соёлоо эрхэмлэн дээдэлж хүүхэд залуучууддаа өвлүүлэх бололцоотой юм.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт “Алсын хараа-2050”-д *Монгол улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар азд тэргүүлэгч орнуудын нэг болох...*-д чиглэж байгаа бөгөөд үүний тулд Эрхэм зорилгоо дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

...- “үндэс язгуур, төрт ёс, өв соёлоо дээдэлж,
- үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж,
- хүн төрөлхтний дэвшилтэт ололтыг дэмжиж,
- хөрст дэлхий, унаган байгалиа хайрлан хамгаалж,
- амар тайван, хүмүүнлэг нийгмийг цогцлоож,
- ардчилал, шударга ёсны засаглалыг бэхжүүлж,
- өөрийгөө тэтгэсэн эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн,
-эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжинө”... (Монгол Улсын Засгийн газар 2020) гэжээ.

Түүнчлэн, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хамгийн эхэнд Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг онцгойлон тусгасан бөгөөд ...Зорилго 1-д, “Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “нэг хэл, нэг түүх, нэг соёл, нэг итгэл үнэмшлийг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно”... (Монгол Улсын Засгийн газар 2019, 86) гэсэн байна. Энэ ажлын хүрээнд, ...Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг судлан тодорхойлж, “Эрдэнийн судар”-т тэмдэглэн үлдээсэн Соёл урлагийн их сургууль, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, их дээд сургуулийн эрдэмтэн судлаачдаас гаргаж буй санал, санаачилгыг Монгол Улсын Ерөнхийлөгч дэмжиж, монгол хүн, гэр бүл, төрт ёс, эх нутаг, монгол хэл, эрдэм боловсрол, ёс суртахуун, өв соёл, нүүдэлчин ухааныг монгол түмний эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс мөн (Ерөнхийлөгчийн тамгын газар 2020) хэмээн үзжээ.

Улмаар, Зорилт 1.2-г, ...“Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно”... (Монгол Улсын Засгийн газар 2019, 95), 1.2.1. “Гэр бүл-монгол соёлын анхдагч орчин” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж, “Монгол хүүхэд”, “Монгол гэр бүл”, “Монгол төрийн гэр бүлийн талаарх бодлого” гэсэн гуравласан холбоог үүсгэж, гэр бүлийн гишүүдийн харилцан хүндлэл, ажил үүрэг, түүний дотор эцэг эхийн үүргийн тэгш хуваарь, эх хүүхдийн халамж, хамгааллын үнэт зүйлсэд

суурилсан уламжлалт ёсыг хадгална”... (Монгол Улсын Засгийн газар 2019, 96), 1.2.4. “Боловсролын сургалтын хөтөлбөрт нүүдэлчин ахуй, зан заншил, өв соёлын агуулгыг тусгаж, бүх шатны боловсролын байгууллагын суралцагчдад үндэсний өв соёл, уламжлалт наадгайн төрлийн мэдлэг, чадвар эзэмшүүлнэ” (Монгол Улсын Засгийн газар 2019, 96)... гэх мэтчилэн зайлшгүй чухал заалтууд олон байна.

Эдгээрийг хэн, хэрхэн хийх вэ? гэсэн асуултад “Өв соёлоо дээдлэгч Бүтээгч Монгол хүн” гэсэн хариулт л гарна.

Миний бие 2017-2019 онд доктор Б.Мөнхцэцэгийн хамт “Нялх хүүхдийн тоглоом наадгайн соёлын утга тайллын судалгаа, орчин үеийн хэрэглээ (Өлгийн зүүвэр наадгайн жишээн дээр)” сэдэвт судалгааны ажил хийсэн ба бид судалгааны асуудлыг 1. Хүүхэд залуучуудыг монгол сэтгэлгээтэй монгол хүн болгон төлөвшүүлэх, 2. Судалгаа шинжилгээний ажлын эцсийн үр дүн амьдралд хэрэгжихүйц байх гэсэн хоёр чиглэлд хандуулсан билээ. Үүнтэй холбогдуулан хүүхэд, залуучуудын сэтгэлгээний өнөөгийн байдлын эерэг сайн тал ч, сөрөг тал ч хүүхэд эхээс мэндлэхэд хүлээн авч буй орчин, эцэг эх, ах дүүсээс үзүүлж буй хайр халамж, асрал энэрэл өөрчлөгдөж буйтай ихээхэн холбоотой хэмээн үзэж байгаа тул “Хүнээр хүн хийх монгол арга ухаан”-ы ай сав руу, нэн ялангуяа монголыг монголоор нь авч үлдэж, хөгжүүлэх сэтгэлгээтэй монгол хүн болон төлөвшихөд хүүхэд залуусыг хэдийнээс эхлэн бэлдэх нь зүйтэй вэ? гэдгийг юуны өмнө тодорхойлохыг зорьж судалгаагаа эхлүүлсэн ба үр дүнд нь монгол хүн болж төлөвших хамгийн анхны гараа нь шинээр төрсөн хүүхдийн “угаалгын зан үйл”-ээс эхэлнэ хэмээн үзсэн ба энэхүү зан үйлийн бэлгэ тэмдэг болох монгол нялхсын өлгийн зүүвэр наадгайн утга учрыг судлан, олон нийтэд сурталчлан таниулж, дагаж мөрдөж, жинхэнэ монгол хүүхэд залуусыг төрүүлж, өсгөж хүмүүжүүлэхэд бодитой үйл ажиллагаа зохион байгуулах санал санаачилга, уриалга гаргах зайлшгүй шаардлагатай байгааг энэ удаагийн судалгааны ажлаараа дэвшүүлж байлаа.

Иймээс энэ удаа “Өв соёлоо дээдлэгч, бүтээгч монгол хүн”-ийг олохын тулд өвөг дээдсийнхээ үлдээж өгсөн “Хүнээр хүн хийх монгол арга ухаан”-ы ай саваас эрж хайсны үр дүнд дараах чухал эрдэнийг олсноо та бүхэнтэйгээ хуваалцахыг зорилоо.

Судалгааны арга зүй

Судалгаанд түүхэн сурвалж судлал, соёлын антропологи, угсаатны зүй, монгол тоглоом наадгайн уламжлалт агуулгыг баримтлан шинжилсэн. Мөн бэлгэдэл зүйн болон сэтгэл судлалын тайлбарын арга зүйг судлаачдын бүтээлд тулгуурлан холбон ашигласан. Энэ нь өлгийн зүүвэр наадгайн соёлд шингэсэн хүмүүжлийн болон бэлгэдлийн утга, үнэт зүйлийг олон талаас нь тодруулахад чиглэсэн.

Судалгааны үр дүн

Өлгийн зүүвэр наадгай гэдэг нь шинэ төрсөн хүүхдийн угаалгын зан үйлийн үед эцэг эх, ах дүүс, авсан ээж зэрэг ойр дотны хүмүүс нь шинэ хүнд зориулан хийж өлгийн бүснээс нь зүүж бэлэг болгон өгсөн эсгий үнэг, тээг, хонх, явуу, жижиг нум сум, уурга, чөдөр, тушаа гэх мэт монгол ахуйгаас үүдэлтэй олон зүйлийн утга бэлгэдэлт зүйлсийг нарийн сураар холбож багцалсан, өлгийтэй хүүхдийн толгойн харалдаа, нүдэнд нь харагдахуйцаар монгол гэрийн унинаас дүүжилдэг наадгайн зүйл юм.

Энэ наадгайг монгол хүүхдийн хамгийн анхны амьдралыг таньж мэдэх оньс түлхүүр, ном, багшийг төлөөлөх эд зүйл, өмч гэж үзэж болно. Үүнд л зүүвэр наадгайн гол үүрэг ач холбогдол, үнэ цэн нь оршино. Мөн нярай үеийн тоглоом наадгай нь нялх бага насны хүүхдүүдийн тоглоом бөгөөд тэдгээр нь нярай үеийн мэдрэмж, оюун ухаан, бие бялдрын өсөлт хөгжилт, цаашдын хүмүүжил төлөвшилд чиглэсэн, монголчуудын бэлгэдэлт сэтгэлгээг илэрхийлсэн утга агуулгат дүрс хэлбэрээс тогтсон зүйлс байдаг байна (Зураг 1).



Зураг 1. Монгол нялхсын өлгийн зүүвэр наадгай

Монголын уламжлалт нялх бага насны хүүхдийн тоглоом наадгайн зүйлс нь хүүхдийг монгол хүн болгон өсгөж хүмүүжүүлэх, хөгжүүлэхэд танин мэдэхүйн суурь ач холбогдол нэн өндөр байдаг. Хүүхэд өсөж том болохыг дагалдан тоглоом наадгайн зүйлсийн хэрэглээ нь ч мөн нарийсаж, хүүхэд хөлд ороход хонхыг нь бойтог, гуталд нь, явуу, зоос тэргүүтэй зүйлсийг дээлийн ард, захны доор болон хоёр мөрөнд нь хадаж, хүүхдийг элдэв муу зүйлээс хамгаалахын зэрэгцээ хувцасны чимэг зүүсгэл болгон ашигладаг уламжлалтай байсан ажээ.

Шинээр мэндэлсэн монгол нялх хүүхэд анх нүдээ нээгээд ээжийгээ харсны дараа аавынхаа хайчилсан эсгий үнэг, угаалгын ёслолын бэлэгт ирсэн тээг зэрэг тэргүүтэй монгол ахуйгаас үүдсэн зүүвэр наадгайн зүйлсийг харж орчлон хорвоотой анхлан танилцана. Энэхүү эцэг эх, ахан дүүсийн хайр халамж, сайн сайхны ерөөл шингэсэн бэлгэдлээр бүрдсэн наадгайн зүйлс түүнд орчлон ертөнцийн талаарх болон эцэг эх, ах дүүсийн сэтгэлийн холбооны тухайд хамгийн анхны мэдээ мэдээлэл дамжуулах дохио тэмдэг болж, түүний сэтгэхүйн гүнд буюу нэг ёсондоо санах ой, далд ухамсарт нь хадгалагдан үлддэг гэж үзэж болно. Ингэж монгол хүүхэд биологийн шинжээс нийгмийн шинжид шилжин, хүн байгалийн нэгэн хэсэг болсноо мэдэрдэг.

“Хүүхдийн угаалга” хийх зан үйлийг тухайн хүүхэдтэй холбоотой хамгийн анхны зан үйл гэж үзэж болох ба энэ талаар угсаатны зүйн чиглэлийн хүрээнд

нэлээд судлагдсан байна. Харин сүүлийн үед соёл судлал, соёлын хүн судлал, түүн дотор хүүхэд насны соёлыг судлах зэрэг судалгаа шинжилгээний салбар, чиглэлээр нарийвчлан судалж эхлээд байна. ...Хүүхэд насны соёл нь олон соёлт орчин дахь хүний адилслын нэгэн салбар бөгөөд даяаршлын нөхцөлд угсаатны ухамсрыг тээгч, нэгэн угсаатны төлөөлөл болохын хувьд өөрийн угсаатны адилсалтай, итгэлтэй байх боломжийг олгодог (Ганжаргал 2018, 51-60) тул монголчуудын хүүхдийн угаалгын зан үйлийг монгол соёлын орчин дахь монгол хүний адилслын анхдагч суурь нь юм гэж үзэж болно. Мөн түүнчлэн, "...Хүүхдийн угаалгын ёслол бол монголчуудын оюуны соёлын томоохон зан үйл..." (Ганжаргал 2018, 51-60) ба "насны гурван хурим"-ын анхных тул "...заавал ёсолдог амь амьдралын баталгаа шинжтэй..." (Дулам, Нандинбилиг 2015, 83) гэсэнтэй ч бид бас санал нэгтэй байгаа ба үүнийг өлгийн зүүвэр наадгайг бүрдүүлэгч зүйлсийн утга агуулгаар тайлбарлаж болох юм. Тийм ч учраас угаалгын зан үйлтэй шууд холбоотой монгол хүүхдийн өлгийн зүүвэр наадгай өнөөг хүртэл мартагдахгүйгээр үл барам утга учрыг нь нарийн мэдэхгүй ч уламжлагдан хэрэглэгдсээр байгаа монгол соёлын адилсал (менталитет) юм. Үүнийг судлаачдын угсаатны зүйн хэрэглэгдэхүүнд үндэслэн тайлбарласан наадгайг бүрдүүлэгч зүйлсийн бэлгэдэлт утгаас мэдэж болно (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Өлгийн зүүвэр наадгайг бүрдүүлэгч зүйлсийн бэлгэдэлт утга¹

Наадгайн зүйлс	Бэлгэдэл	Хандаж буй хийсвэр ертөнц	Дом
Эсгий үнэг		Ад элиэ	Ал элиэг эндүүрүүлэх дом
Бэл	Төрийн хар хүн	Төрийн сүлд	
Есөн нүх	9 тоо	Мөнх тэнгэр	Таниулах дом
Онгин ба дөрвөлжин тээгийг эрэгтэй хүүхдэд	Газар нутгийн эзэн суух	Наран тэнгэр	Гэмтэх бэртэхээс хамгаалах дом
Саран ба гурвалжин тээгийг эмэгтэй хүүхдэд	Нутаг ус	Саран тэнгэр	
Зоос	Бэл бэнчин	Эдийн тэнгэр	Эд баялаг дуудах дом
Өлзий зангиа	Ам бүлийн бат холбоо	Ургийн тэнгэр	Амь насыг зангидах
Загасан нуруу	Нурууг бэлгэдэх	Лус	Усны аюулаас хамгаалах
Эр эм явуу	Цэвэр ариуныг		Энхэр хүүхдийг хамгаалах
Хушга	Эр бэлгийг	Эцгийн тэнгэр	Удам залгах дом
Гахайн соёо, голхи	Газар нутаг гуйх	Газар эх, /лус савдаг/	Лус савдгийн хорлолоос хамгаалах дом

¹ Нандинбилиг 2010, 142

Наадгайн зүйлс	Бэлгэдэл	Хандаж буй хийсвэр ертөнц	Дом
Эсгий үнэг		Ад элиэ	Ал элиэг эндүүрүүлэх дом
Бэл	Төрийн хар хүн	Төрийн сүлд	
Есөн нүх	9 тоо	Мөнх тэнгэр	Таниулах дом
Жижиг цоож	Амь насыг цоожлох	Заяагч	Ороодог хүүхдийг тогтоох
Жижиг нум сум	Мэргэн харваач болохыг	Ангийн тэнгэр	Муу юмыг айлгах дарлагын дом
Чоно	Сүлд хийморийг	Чоно тотем	Аз хийморьтой явах
Буга	Урт насыг	Буга тотем	Урт наслах
Адуу	Хүлэг унааг	Унааны тэнгэр	Унаатай явах
Эрхий ороох сур	Адуу малтай болох	Адуу малын тэнгэр	Адуу малтай болох

Хүүхдийн угаалгын үед бэлтгэдэг эдгээр зүйлс нь жирийн тоглоом наадмын чанартай төдий биш, аз жаргал, сайн сайхныг бэлгэдэн гай зэтгэрээс хамгаалах зан үйлийн зориулалттай болох нь бэлгэдэлт утгаас ойлгогдож байна. Энэ талаар судлаачид “...хуучны шүтлэгийн ойлголт ёсоор бол шинэ төрсөн хүүхдэд хор хөнөөл хүргэж болзошгүй далдын онгоныг хуурахад чиглэсэн зүйл юм...” (Сампилдэндэв 2015, 101-102) зэргээр өөрсдийн судалгаанд үндэслэсэн тайлбаруудыг өгсөн байдаг. Бид ч бас дээрх зүүвэр тоглоомыг бүрдүүлэгч эсгий үнэг, загасны нуруу тээг, нум сум, зоос, хонх тэргүүтнийг хүүхдэд хор хөнөөл хүргэж болзошгүй далдын онгоныг хуурахад чиглэсэн, эцэг эх, ахан дүүсийн хайр халамжийн илэрхийлэл хэмээн үзэж байгаа билээ.

Хүүхдийн угаалгын зан үйлийн дотор хүүхдэд “нэр өгөх” чухал нэгэн үйл бас байдаг. “Нэр өгөх” гэдгийн хүндэтгэл нэр нь “нэр хайрлах” гэсэн хэллэг байж таарна. Эндээс тухайн хүүхдэд нэр хайрлан, хайр халамжаа илэрхийлсэн бэлгэдэлт зүйлсийг өлгийн бүснээс нь зүүж өгөх зэрэг үйл нь хайр хэмээх нэгэн үндэстэй, хүнд дутагдаж болшгүй хайрын сэтгэлээс угшилтай хэмээн үзэж, Э.Фроммын хайрын тухай үзэл баримтлалын үүднээс тайлбарлахыг хичээв. Орчин үеийн сэтгэл судлалын онолын үүднээс тайлбарлавал, “Хүн төрнө гэдэг нь инстинкттэй адил өгөгдсөн байсан нөхцөл байдлаасаа гэнэт тасарч, цоо шинэ, тодорхойгүй, яаж ч өөрчлөгдөж мэдэхээр нөхцөл байдал руу шидэгдэх мэт болдог гэнэ. Ингэж эхийн хэвлийд байсан үеийн нэгэнлэг байдал буюу эх үрийн симбиотик нэгдэл төрсний дараа өөрчлөгдөхөд хүүхэд ганцаардмал байдалд ордог байна. ...Эх үрийн симбиотик нэгдэл төрсний дараа өөрчлөгдөхөд хүүхдэд хэрэгтэй хамгийн чухал зүйлсийг (сүү, биеийн дулаан ... гэх мэт) эх нь өөрийнхөө дотор амьд буй зүйлсээсээ үргэлжлүүлэн өгч, хүүхдийнхээ амьдрах боломжийг тэлж, цаашлаад өөрөө өөрийнхөө амьд байх сэтгэлээ хүртэл хүч оруулж чаддаг...” (Фромм 2015, 24-32) гэсэнтэй холбон үзэж болмоор санагдана. Эх үрийн симбиотик нэгдэл төрсний дараа өөрчлөгдөхөд хүүхдэд төрдөг тусгаарлагдсан байдал нь айдас төрүүлдэг ба айдсын шалтгаан болдог гэнэ. Хүн төрөх үеийн сэтгэл зүйн энэ нарийн үйл явцыг

хүн төрөлхтөн эртнээс мэддэг байсан ба эрт үедээ төрөл бүрийн дом шившлэгээр хариулан эерүүлдэг байсны нэг илрэл нь монголчуудын нялх хүүхдийг үнэгчлэхэд эсгий үнэг зэрэг төрөл бүрийн амьтны дүрс бэлдэж домнодог зан үйлийн зүйл байж болох юм. Түүнчлэн, ...“Хүн ерөөсөө тусгаарлагдсан байдлаа хэрхэн даван туулж, бусадтай нэгдэж нийлэх вэ?” гэдэг асуудал байдаг..., ...хүүхэд ээжийгээ хажуудаа байгаа үед тусгаарлагдсан гэсэн ямар ч ойлголтгүй. Тиймээс тэдний ганцаараа байдлыг төрүүлэхийн тулд ээжийн биеэс, ээжийн хөхнөөс болон арьснаас холдуулахад гэнэт ганцаараа болдог. Ингээд хүүхэд тусгаар байдлаа даван туулах хэрэгцээ бий болно... (Фромм 2015, 24-32) Энэ хэрэгцээгээ хүмүүс, үндэстэн угсаатнууд янз бүрийн байдлаар хангасаар ирсэн байдаг. Эдгээрээс хамгийн их хэрэглэгддэг шийдэл бол ...Өөрийнхөө хамт амьдарч буй, нэг үгээр хэлэхэд, өөртөө хамааралтай хүмүүстэй нийцэмтгий байж нэгдэх нэгдэл юм. Үүнд ёс суртахуун, зан үйл, итгэл үнэмшлүүд багтдаг... (Фромм 2015, 24-32) тул “хүүхэд угаах, нэр хайрлах, өлгийн бүснээс бэлгэдэлт дүрстэй зүйлс зүүж өгөх зэрэг бүх л зүйлс шинэ төрсөн хүүхдийг өөрсдийн нэг хэсэг, тусгаар бус гэдгийг түүнд сануулж, нэгэнлэг болж байгаагийн илрэл гэж үзэж болохоор байна. Үүнийг цааш нь лавшруулан ухаарваас, өгөх гэдэг ерөөсөө өөрөө өөртөө хамгийн шилмэл баяр баясгалан.

Хүн өгч байгаагаараа бусдын дотор юу ч байсан амьдрал болгон сэргээдэг. Хүн бусдад үнэнээсээ өгч чадсанаараа бусдыг бас өглөгч болгодог. Ингэж хоёулаа хамтран баясаж, хамтран амьдралд сэрдэг, хамтран сэрээсэн тэр амьдралдаа хоёулаа талархаж эндээс л хайр төрдөг байна... түүнчлэн ...Хайр өөрийнхөө бүх л хэлбэрээр дараах суурь элементүүдийг агуулж явах ёстой аж. Үүнд: бусдыг халамжлах, хариуцлага хүлээх ёс суртахуун, бусдыг хүлээн зөвшөөрөх, мөн бусдыг танин мэдэж чадах чухал байдаг..., ...Хайр гэдэг амьдралд зориулсан халамж, цаашлаад хайртай зүйлээ өсөж хөгжихөд зориулсан үйл хэргээр хэрэгжих халамж ажээ... Хайранд халамжаас гадна хариуцлага гэж байх ажээ. Эрих Фроммын үзлээр, хүмүүс хариуцлагыг үүрэг буюу гаднаас оноогдсон зүйл мэтээр ойлгодог гэнэ.

...Гэтэлжинхэнэ утгаараа хариуцлагын сэтгэлгэдэг нь чөлөөт хүслийн асуудал..., ...Ээж хүн хүүхдэдээ хариуцлагын сэтгэлтэй байх гэдэг нь хүүхдийнхээ биеийн бүх л асуудалд халамжтай байхыг хэлнэ... гээд, ...бусад хүмүүст хариуцлагатай сэтгэл гэдэг мөн өөртөө ч хариуцлагатай байхыг хэлнэ... (Фромм 2015, 24-32) гэж тайлбарлажээ. Харин гурав дахь элемент болох бусдыг хүлээн зөвшөөрөх гэдэг нь ...бусдыг хөгжиж боловсроход анхаарлаа хандуулах гэсэн ойлголт... (Фромм 2015, 24-32)-ыг хамруулдаг байна. Энэ бүхэн хүүхдийн угаалгад оролцож байгаа бүх хүнд хамааралтай гэж ойлгогдож байна. Мөн Жон Боулби-ийн ...Эх үрийн сэтгэлийн хөдөлгөөнтэй харилцаа холбоо нь хүний байгалийн өгөгдлийн салшгүй нэг хэсэг юм. Нялх болон бага насанд хүүхдүүдэд эхийн хайр яг л витамин болон уураг хүний биед ямар хэрэгтэй вэ, түүнтэй адил тэдний менталын эрүүл мэндэд маш чухал ажээ... (DK 2014, 274-275) гэсэн нь бас монгол нялхсын өлгийн зүүвэр наадгайд шингэсэн аав ээж, ахан дүүсийн харамгүй сайхан сэтгэлийн өглөгийн утга агуулга, ач холбогдлыг ойлгуулдаг. Эдгээр утга санааг уран бүтээлийнхээ эх үүсвэр болгон ашиглаж, уран бүтээлээ туурвисан залуу зураачдын бүтээлүүд нь энэхүү соёлыг олон нийтэд сурталчлах, өвлүүлэн уламжлуулах өвөрмөц хэлбэр гэж үзэж болно.

Хэлэлцүүлэг

Бид хүүхэд залууст өв соёлоо уламжлуулахдаа тэдний сонирхолд нийцэхүйц шинэлэг арга замыг эрж хайж сонгон хэрэглэх нь үр дүнтэй юм. Иймээс дараах залуу уран бүтээлчдийн бүтээлийг жишээ болгов.

Орчин үеийн урлаг ба “Өлгийн зүүвэр наадгай”



Зураг 2. Б.Мөнхцэцэг “Эрт ба эдүгээ” инсталляци эсгий, утас (2016-2017)



Зураг 3. Ж.Анунаран “Бүү ай”

Залуу уран бүтээлч, зураач Б.Мөнхцэцэгийн “Цагаан” (2010 он), “Хүй дарсан чулуу” (2016-2017 он), “Эсгий бүтээхүй, бичвэр тайлахуй” (2017 он), Ч.Мөнхцэцэгийн “Эхийн сэтгэл”, Ж.Анунарангийн “Бүү ай” зэрэг орчин үеийн урлагийн бүтээлүүд нь өнөөгийн залуусын сонирхлыг татахуйц бөгөөд эдгээрийг жишээ болгон сонирхож, өөр өөрсдийн нутаг орны онцлогт тохирсон шинэлэг арга, хэлбэрийг сэтгэн, олон төрлийн арга хэмжээ зохион байгуулах бололцоотой юм.

Үндэсний соёлын бүтээлч үйлдвэрлэл ба “Өлгийн зүүвэр наадгай”

Үндэсний соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутгийн брэнд бүтээгдэхүүний загвар боловсруулах боломж бас бий.

Залуу зураач Ц.Солонго өлгийн зүүвэр наадгайг бэлгийн багц болгон урласан нь үндэсний бүтээлч үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болгож буй нь өв соёлоо хэрэглээгээр дамжуулж өвлүүлэх хамгийн шилдэг арга гэж ойлгогдож байна.



Зураг 4. Ц.Солонго. Өлгийн зүүвэр наадгай



Зураг 5. Америкийн уугуул индианчуудын “зүүд манагч”-ийг орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн олон төрлийн бүтээгдэхүүн болгосон нь

Ийм утгатай бэлгийн зүйлс бас америкийн уугуул индианчуудын Ожибвэ омгийнхонд байдгийг энэ удаагийн судалгаагаар илрүүлсэн юм. Энэ нь монгол хүүхдийн өлгийн зүүвэр наадгай, америкийн зүүд манагч зэрэг нь балар эртний

хүмүүсийн зан үйлийг хадгалж ирсэн архетип болохыг харуулахын зэрэгцээ бид бас өлгийн зүүвэр наадгайг бүрдүүлэгч олон төрлийн зүйлсээр залуучуудын өнөөгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүнүүд хийж болох сайхан жишээ болж байна.

Уугуул америкчууд буюу индианчуудын, тэр дундаа Ожибвэ омгийнхонд монголчуудын зүүвэр наадгайтай адил утга агуулгатай, бас адил зориулалттай гэж үзэж болох “Dream cacher” буюу зүүд манагч хэмээх наадгай тэдний хамгийн гайхалтай өв уламжлалын нэг гэнэ. 1960-1970-аад оны үед америкчуудын дунд тархсан энэхүү бяцхан эд олон домог яриа дагуулдаг. Зарим нь энэ бол уугуул америкчуудын эв нэгдлийн бэлгэдэл гэж үздэг байхад нөгөө хэсэг нь хүний зүүдний ертөнц дэх хамгаалагч гэж үздэг ажээ. Энэ утгаараа манай нялх хүүхдийн “үнэгчлэх” гэдэгтэй адил юм.

Энэ нь унтаж буй хүнийг муу муухай зүүднээс хамгаалж, өөрөөрөө дамжуулан сайн сайхан зүүдийг л бэлэглэх чадалтай. Сайхан зүүд нь зүүд манагчийн голд байх нүхээр дамжин орж, доош унжсан өд сөдөөр гулсан унтаж буй хүнд хүрдэг учиртай. Харин муу муухай зүүд аалзны тор мэт утсанд хүлэгдэн үлдэж, нарны анхны туяанд замхран алга болдог. Зүүд манагч нь хэдэн үе дамжин уугуул америкчуудын өв соёлын нэгэн хэсэг байсаар байгаа юм. Энэ нь мөн бүслүүр, цагаригаас үүсэлтэй гэгддэг. Учир нь цагариг бол тухайн оронд хүч чадал, нэгдмэл байдлын илэрхийлэл болдог. Цагаригаас үүсэлтэй олон бэлэг тэмдэг байдгийн нэг нь энэхүү зүүд манагч юм.

Зүүд манагчийн тухай ийм нэгэн домог америкийн угсаатны зүй судлаач Франсес Дэнсморийн “Чиппэва” номд тэмдэглэгджээ. ...Мөчир, булчин шөрмөс, өд сөд гэх мэт зүйлээр хийдэг байсан эртний зүүд манагчид ихэвчлэн шинэ төрсөн хүүхдэд өвөө эмээгээс нь уламжлагдан ирдэг бөгөөд нэг талаар анхны эд хогшил нь болдог байжээ. Тиймээс өвөө эмээ нар бяцхан хүүхэд унтаж байхад зүүд манагч хөдлөх нь сайн сайхныг зүүдэлж байна хэмээн баярладаг гэнэ (Native Teach 1995). ...Шөнийн агаарт сайн муу зүүд холилдон байх бөгөөд сайн зүүд нь аалзны тор мэт зүүд манагч дундуур хэрхэн гарахаа мэддэг гэж тэд үздэг. Харин өд бүхний хөнгөн хөдөлгөөн илүү сайхан зүүд дуудах чадалтай байхад, муу зүүд улам бүр төөрөлдөж, өглөөний нарны туяанд бяцхан шүүдэр шиг хайлан алга болдог хэмээн домогт бичжээ.

Харин тэдгээр (өлгийн зүүвэр наадгай, зүүд манагч)-ийг өдий хүртэл уугуул шинжээр нь өвлөн авч яваа үндэстэн угсаатнууд цөөн байдаг боловч одоогийн америкчууд овжиноор ашиглан эв нэгдлийн бэлгэ тэмдэг болгон дэлхийн нийтээр тараан олон улс орны залуучууд түүнийг сонирхон хэрэглэдэг, сайныг ерөөсөн бэлэг дурсгал болгон хэрэглэдэг заншил тогтоод байгаа ажээ. Мөн сүүлийн үед манай Монголд энэ зүүд манагч дэлгэрсэн бөгөөд захиалгаар хийж худалддаг байна. Иймд залууст “Өлгийн зүүвэр наадгай”-н тухай мэдлэгийг түгээж, “Зүүд манагч” шиг олон төрлийн бүтээгдэхүүн урлан үйлдвэрлэх санааг өдөөж өгөх нь чухал юм.

Дүгнэлт

Монгол нялхсын өлгийн зүүвэр наадгай нь зөвхөн нярай хүүхдийн хамгаалалтын хэрэгсэл төдийгүй хүн төрөлхтний балар эртний сэтгэлгээний архетип, монголчуудын онцлог шингэсэн үндэсний соёлын адилслын өвөрмөц илэрхийлэл юм. Энэ нь америкийн уугуул Ожибвэ омгийн “зүүд манагч”-тай утга төстэй боловч, зүүвэр наадгайн бүрдэлд багтдаг эсгий үнэг, тээг зэрэг олон зүйлс нь аав ээж, ахан дүүсийн хайр халамж, ерөөл ертөнцийн бэлгэдлийг хүүхдийн сэтгэлийн гүнд шингээж, монгол хүний үндсэн ухамсар, хүмүүжлийн эхлэлийг тавьдаг онцлогтой.

Өлгийн зүүвэр нь нялх балчир хүүхдийн байгалиас заяасан зөн совингоор дамжин сэтгэлийн гүнд нь хадгалагдаж, насан туршид нь ураг төрлийн элгэмсэг холбоо, монгол ахуй, соёлын үнэ цэнийг сануулж байдаг. Монгол хүүхэд түүгээр дамжин ертөнцийн юмс үзэгдлийг танин мэдэж байдаг.

Түүнчлэн зүүвэр наадгай нь нярай насанд хамгаалах, ерөөх зориулалттай байсан бол хөлд орсон үеэс чимэг зүүсгэл болон ахуйн хэрэглээнд шилжиж, үүрэг зориулалт нь өргөждөг уламжлалтай. Энэ нь түүнийг олон төрөл зүйлтэй болгон хөгжүүлэх, гоёл чимэглэл, бэлэг дурсгалын зүйл болгон ашиглах өргөн боломжтойг харуулж байна.

Өсвөр насны хүүхэд, насанд хүрэгчид ямар төрлийн зүүвэр зүүхээ зүгээр нэг гоёл бус, харин өөрийнхөө гарвал, итгэл үнэмшлээ илэрхийлэх ухамсарт сонголт гэж ойлгох нь зүйтэй. “Өлзий зангиа”, “жигжиг цоож”, “нум сум” зэрэг зүүврүүд нь тухайн хүний амьдралын философи, соёлын ухамсар, үндэсний адилслыг илэрхийлэгч бэлгэдэл болон хувирч болно.

Мөн олон нийтийн дунд явуулсан судалгааны үр дүн, залуу уран бүтээлчдийн соёлын бүтээлч үйл ажиллагаа, орчин үеийн залуусын “зүүд манагч”-ийг сонирхох хандлага нь зүүвэр наадгайн уламжлалыг дахин сэргээж, шинэчлэн хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг нээж байна. Иймд зүүвэр наадгайн уламжлалыг зөвхөн хадгалах бус, боловсрол, хүмүүжлийн бодлого, бүтээлч үйлдвэрлэлд уялдуулан сэргээх, шинэ хүүхдийн угаалгыг уламжлалт утгаар нь зохион байгуулах, соёлын ухамсрыг төлөвшүүлэхэд чиглэсэн бүтээлч үйл ажиллагаа явуулах нийгмийн шаардлага өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж байна.

Ашигласан материалын жагсаалт

Ганжаргал, М. 2018. “Хүүхдийн угаалгын ёс соёлд орохуйн (инкультурацийн) зан үйл болох нь.” *Монголын соёл, урлаг судлал* XXVI: 51-60.

Дулам, С., Нандинбилиг, Г. 2015. “Насны онцлогтой холбоотой монгол заншлууд.” *Аман зохиол судлал: Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний цуврал* XXXVI: 83-90.

Ерөнхийлөгчийн тамгын газар. 2020. “*Эрдэнийн судар*”-ыг дээдлэн залах тухай. Улаанбаатар. 2025.03.17. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231084991741>.

Монгол Улсын Засгийн газар. 2019 *Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал*. Улаанбаатар.

Монгол Улсын Засгийн газар. 2020. *Алсын хараа 2050: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*. Улаанбаатар. 2025.03.17.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1>

Нандинбилиг, Г. 2010. "Монгол тоглоомын соёл хийгээд тэнгэр, лус савдгийн шүтлэг." *Монгол улсын их сургууль, Монгол хэл соёлын сургууль эрдэм шинжилгээний бичиг* Том. XXXII (340): 139-143.

Сампилдэндэв, Х. 2015. *Монгол зан үйл судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Фромм, Э. 2015. *Хайрлах урлаг*. Улаанбаатар: Монсудар.

ДК. 2014. *Психологи*. Орч. Молор-Эрдэнэ С., Жавзан Б., Мягмаржаргал П., Ундармаа Г. Улаанбаатар: Монсудар хэвлэлийн газар.

Native Teach. 1995. *Dreamcatchers: Their history and use*. 2025.06.16. <https://nativetech.org/dreamcat/dreamcat.html>.